



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч”  
/брокер/-ийн үйл ажиллагаанд авах зарим арга  
хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 26.2.13 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 6 хуулийн этгээдийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1/ Хавсралтад дурдсан нэр бүхий 6 хуулийн этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн 0.08 хувиас доошгүй байхаар 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 12 сарын хугацаатай тогтоосугай.

2/ Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллахыг Ажлын алба /Б.Ариунаа/, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Долгорсүрэн/-д тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст төвлөрүүлж ажиллахыг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/-д үүрэг болгосугай.

3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг үүрэг болгож, цаашид зөрчил давтан гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх болохыг хавсралтад дурдсан нэр бүхий 6 хуулийн этгээдийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА




С.ДАВААСҮРЭН

E:\ajil 2018\Blank\Togtool.doc

00824

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 12 дугаар сарын 14 –ний өдрийн  
37 дүгээр тогтоолын хавсралт



Д/Д	ХААБ-ИЙН НЭРС
1	“МЭТУ ХААБ” ХХК
2	“ХАНБҮРГЭД ХЭНТИЙ ХААБ” ХХК
3	“АЛТАНШАГАЙ ИМПЕКС ХААБ” ХХК
4	“БАДАРХУНДАГА ОРГИЛ ХААБ” ХХК
5	“САНТЛАНС ХААБ” ХХК
6	“БАЯРПЛАНТ ХААБ” ХХК